



Монголын Нууц Товчоо (МНТ)-ны анхны хятад орчуулга

Л.Манлажав* (ХИС)

МНТ бол монголчуудын түүхэндээ үлдээсэн олон оньсгуудын нэг. Энэхүү дурсгалын бичгийн хадгалагдаж үлдсэн түүх нь судалгааны тусгай сэдэв бөгөөд одоо ч гэсэн мөн судалсаар байна. МНТ-г судлах бас нэг чиглэл бол гадаад олон хэлэнд буулгасан орчуулга гэж үзэж болно. Орчуулгын тухай өгүүлэхийн тулд юуны өмнө эхийн талаар товч боловч авч үзэх нь зүйтэй.

МНТ нь 15 бүлэгтэй ба 12 бүлэгтэй хоёр эх бичгээс бүрдсэн, агуулгын хувьд үндсэндээ хоорондоо ялгаагүй. Энэхүү хоёр төрлийн эх нь хоёул 282 хэсэгтэй бөгөөд ийнхүү дугаарласан нь судалгааны ажилд дөхөм болгохын тулд хожим нэмж хийсэн зүйл юм. МНТ-ны эх нь монгол хэлээр тэмдэглэгдсэн боловч, монгол бичгээр бичсэн эх нь хараахан олдоогүй байна. МНТ-ны 282 зүйлийн 234 нь Лу. Алтан Товчид багтсан бөгөөд МНТ-нд байхгүй хэсгүүд ч уг бүтээлээс олдсон нь МНТ-ны эх уйгуржин монгол бичгээр байсны гэрч гэж ихэнх судлаачид үздэг. Уйгуржин монгол үсгийн эх байсны ул мөрийг МНТ-ны галиг болон хэлний бусад жишээ баримтаар бас нотолж болно. Мин улсын Хун-У (洪武) хааны 15-р онд (1382) хэвлэсэн анхны хэвлэлийн 41 хуудас бүрэн бус цорын ганц эх хувь²⁴ үлдсэнийг энэ ялдамд дурьдахад түүхэн он цаг улирах тутамд ном судар хадгалагдан үлдэх нь их ховор тохиол болохыг харуулж байна.


Манай үеийг хүртэл хадгалагдаж ирсэн хоёр эх хоёул монгол хэлээр хятад ханз үсгээр тэмдэглэгдсэн байгаа. Монгол эхийн үг бүрийн хажууд хятад хадмал орчуулгаас гадна, хэсэг бүрийн хойно хятад товч орчуулга хавсаргасан нь МНТ-г гадаад хэлэнд буулгасан анхны орчуулга юм. Энэхүү бүрэн эхийг Мин улсын Юн Лө хааны нэвтэрхий толь бичиг (永樂大典)-т хэвлүүлэн гаргаснаар хадгалагдан үлджээ. Үүнээс хойш олон удаа янз бүрийн эмхэтгэлд оруулан хэвлэсэн байна.

*ХИС-ийн профессор, доктор

²⁴大漢的世界紀家元時の多元文化與藝術(Age of Great Khan, Pluralism in Chinese art and culture under the Mongols) Tai-Pei 2008. P47, (Catalogue of National Palace Museum in Tai-Pei)



Зураг 1. Мин улсын Юн Ло хааны үе



Зураг 2. 15 бүлэг бүхий МНТ

Энэхүү илтгэлд МНТ-ны анхны буюу товч орчуулгын тухай өгүүлэхийг зорьсон юм. МНТ-г түүхэн эх сурвалж болгон ашиглаж байсан Европын болон Хятадын эрдэмтдийн нэлээд хэсэг нь чухамхүү энэ хятад товч орчуулгыг ашиглаж байв. Жишээлбэл, П.Кафаров²⁵ эхлээд хятад товч орчуулгыг олж авч, 1866 онд орос хэлнээ орчуулсны дараа 1872 онд 15 бүлэг бүхий бүрэн эхийг олж, түүнийг улмаар Европ дахинд танилцуулжээ.

Хятадын эрдэмтэн Цянь Да-синь (錢大昕) эхлээд 15 бүлэгтэй эхийг олж үзсэн бөгөөд хожим нь 12 бүлэгтэй эхийг олж авч, харьцуулан үзсэн байна. Хятадын эрдэмтдээс Цянь Да-син анх түрүүн МНТ-нд анхаарлаа хандуулсны ачаар тэр үеийн хятадын эрдэмтэд, тухайлбал Ли Вэн-тянь (李文田), Ван Го-вэй (王國維) зэрэг эрдэмтэд МНТ-г түүхэн сурвалжийнх нь хувьд цоо шинээр үнэлэн цэгнэж, МНТ-ны судалгаа идэвхжин, олон тооны бүтээл гарсан байна.

Харин 12 бүлэгтэй эхийг анх 1804 онд Гу Гуан-чи (雇廣圻) олсон бөгөөд 1805 онд уг номыг хэвлүүлснийг Ли Вэнь-тянь, Вэнь Тин-ши (文廷式) нар 1902 онд Японы эрдэмтэн Найто Торозиро (内藤虎次郎)-д бэлэглэж, тэрээр цааш нь Нака Митие (那珂痛世)-д өгснийг, орчуулан олон тооны тайлбар зүүлтийн хамт 1907 онд хэвлүүлжээ.²⁶

Дээр өгүүлсэн хоёр төрлийн бүрэн эхээс гадна, МНТ-ны хэвлэгдсэн нэг хувилбар бол хятад орчуулгыг тусгайлан хэвлэсэн эх юм. Хятадын бичгийн хүмүүс Жан Му (張穆), Хэ Цю-тао (何秋濤) нар тусгай эмхэтгэлд оруулан, Дао Гуаны (道光) 27-р онд (1847) хэвлүүлжээ.²⁷

²⁵П.И.Кафаров, 1866: Старинное Монгольское сказание о Чингисхане: Генеалогическая таблица к сказанию о Чингисхане, том IV, с. 1-258, С.-Петербург


²⁶成吉思汗實錄, 東京, 1907,

²⁷元朝秘史 (十五本) 連筠移菴書, 道光二十七年秋靈石楊氏刊本

МНТ-ыг бичсэн хугацааг 1240 он гэж үздэг бол хятад галигаар буулгаж Орчуулгын хамт хэвлэсэн оныг 1383-1404 он гэж үздэг. Энэ нь Мин улсын Хун У хаан хэрэглэгдэхүүн болгон ашиглахыг зарлиг болгосонтой холбоотой. Мин улсын Юн Лө-учраас 1404 он бол чухал он юм. Ийнхүү МНТ-г 1382-1404 оны хооронд хятад хэлнээ орчуулжээ гэж үздэг. Монгол хэлийг хятад хүмүүс чухалчлан судалж байсан нь улстөр-цэргийн ач холбогдлоос гадна, монгол хэл тэр үеийн чухал хэлний нэг байсан бололтой. XIII-XIV зууны үеийн бичгийн дурсгалын зүйлсийг хадгалсан Турфаны бичсэн баялаг олдвор байдгийн дотор монгол хэлээр уйгуржин, дөрвөлжин хоёр ч төрлийн үсгээр бичсэн хэрэглэгдэхүүн байдгийг бид олж үзэж болно.

МНТ-ны эхийн хэл нь тэр үеийн монгол хэлний онцлогийг, тухайлбал бичгийн болон ярианы хэлний онцлогийг тусгасан гэж үздэг. Энэхүү эх бичгийн хятад товч орчуулга нь өвөрмөц хэлтэй. Орчуулгын хэлнийх нь онцлогийг М.К.Холлидей²⁸ бүтэц хэл шинжлэлийн үүднээс судалсан байдаг. Тэрээр хятад хэлний эх сурвалж болгон судалж, онцлогийг нь авч үзсэнээс бус, монгол хэлний эхтэй харьцуулан судлаагүй бөгөөд харин орчуулгын зарим онцлогийг монгол хэлний нөлөө хэмээн тайлбарласан зүйлс бий.

М.К.Холлидей МНТ-ны хятад товч орчуулгын хэл нь тэр үеийн бичгийн хэлний (文言) хэм хэмжээнээс өөр, хойт зүгийн нутгийн аялгуунд тулгуурласан, ярианы хэлэнд илүү ойр хэлээр буулгасан хэмээн тэмдэглэжээ. Ийнхүү сонгодог бичгийн хэлнээс ялгаатай хэлээр бичсэн нь хятад эрдэмтэд орчуулгыг дахин найруулан засах оролдлого хийхэд хүргэж байв.²⁹



Зураг 3-5. МНТ-ны хятад хэлээр орчуулсан эхүүд

Ийнхүү хятадын хэлбичиг, түүхийн эрдэмтэд ном зохиолын хэл найруулгыг бичгийн хэлний хэм хэмжээнд нийцүүлэх өндөр шаардлага тавьдаг байсан боловч, МНТ-ны товч орчуулгыг түүхэн сурвалж болгон ном зохиолдоо ашиглаж байв.

²⁸ Halliday M.A.K., 1959: The language of the Chinese "Secret History of Mongols", Oxford

²⁹ 元秘史潤文，清光緒末年王氏清稿本，楷書

Ер нь МНТ-ыг судлаачид франц, герман, орос, англи, япон, хятад гэх мэт олон хэлний хэрэглэгдэхүүн ашиглахын зэрэгцээ МНТ-д хавсаргасан үгчилсэн болон товчилсон хятад орчуулгыг заавал харгалзан үздэг.

МНТ-г гадаадын 26 хэлэнд буулгасан орчуулгын зөвхөн цөөн хэсэг нь дундад үеийн монгол хэлнээс буулгасан эхээс орчуулсан эрдэм шинжилгээний орчуулга, харин нэлээд нь орчин цагийн монгол хэлэнд буулгасан эхээс орчуулсныг бид олж үзэж болно.

Энэхүү илтгэлд авч үзэж байгаа анхны орчуулгыг яагаад товч буюу ерөнхий орчуулга хэмээн үздэг вэ? Үүнийг юуны өмнө орчуулгын хэсэг бүрийг монгол эхтэй нь тулган үзэх ёстой. Жишээлбэл, МНТ-ны §247-282-дох зүйлийн хятад орчуулгыг монгол эхтэй нь тулган үзэхэд, мөрийн тооны хувьд монгол эх нь илүү олон байв. Энэ нь нэг талаар монгол хэлний үг олон үетэй учраас илүү олон мөртэй байх нь ойлгомжтой. Монгол эхийн 3 мөр хятад орчуулгын 1 мөртэй тэнцэж, утгыг бараг товчлохгүй орчуулсан байх жишээтэй. Эх бичиг, орчуулгын эх хоёрын харьцаа 3:1-ээс илүү гарсан тохиолдолд тэр хэсгийг нэлээд хураангуйлан орчуулсан харагдана. Их товчилсон хэсгүүдийн жишээ гэвэл, §254-ийн монгол эх 62 мөр байхад орчуулга нь 12 мөр, §278-ын эх 87 мөр байхад орчуулга нь 2 мөр хүрэхтэй, үгүйтэй, §202-ын монгол эх 3 мөр гэтэл хятад орчуулга нь 3,4,2 мөр, §281-ийн монгол эх 27 байхад орчуулга нь 4,5 мөр байх жишээтэй.

§278-д Өгөөдэй хаан хэвтүүл, хорчин, торгууд, бүх хишигтний тухай хаан эцгийн зарлигийг урьдын ёсоор дагаж мөрдөхийг зарлиг буулгаж, тэдний үүргийг нэг бүрчлэн дахин нарийн тодорхой зааж өгснийг тэмдэглэжээ. Гэтэл хятад орчуулгад зөвхөн хамгаалагч (守街的) гэсэн нэрийг хэрэглэж, “хаан эцгийн зарлигийг урьдын ёсоор дагаж мөрдөхийг дахин сануулав” гэсэн товч зүйлийг бичжээ.

§202 зүйлийн монгол эхэд “...эсгийн туургатан улсыг нэгэнтгэж, есөн хөлт цагаан тугаа мандуулаад..., Мухулайд улсын ван цол өгч, Зэвийг Найманы Күчүлэгийг дарахыг зарлиг болгож, ... улс байгуулахад гавъяа байгуулсан 95 хүнийг мянганы ноён болгосон тухай өгүүлж, нийт хүмүүсийн нэрийг дурдсан байдаг. Гэтэл хятад орчуулгад “... улс байгуулахад гавъяа байгуулсан 95 хүнийг мянганы ноён болгов.” гээд нэрийг нь орхигдуулсан байна.

§64 бол Ц.Дамдинсүрэн гуай “хуримын дуу” хэмээн нэрлэсэн шүлэглэсэн хэсгийг МНТ-ны толгой холбосныг орчин цагийн монгол хэлэнд буулгасан эхээр нь авч үзье.

.... манай Хонгириад хэзээнээс бусдын нутаг ба хүмүүсийг тэмцэлддэггүй гээд

Харь улсыг үл довтлон

Хацар сайн охидоо

Хасаг тэргэнд суулгаж,

Хар буур хөллөж,

Харьгиулж одож,

Хаан болсон та нартаа

Хатан сууринд дэвшүүлэн,

Хамт суулгамой.

Өөр иргэнийг үл тэмцэн,

Өнгө сайтай охидоо

Өлзийт суудалтай тэргэнд суулгаж,

Өл буур хөллөж, үүсгэж одож

Өндөр суурь эзлэгсдийн

Өрөөл хань болгомуй.

Хятад хэлэнд энэ бүх мөр бадгуудыг 1, 9 мөрт багтаан хүүрнэх хэлбэрээр орчуулжээ. Үүнд:

俺翁吉 la 家在前日子裏不與人爭國土百姓但有顔色的女子便獻與您皇帝人家后妃位子裏教坐有來

§106-д Жамуха хэрхэн тулалдаанд бэлэн байгаагаа Тэмүүжин анд, Тоорил хан хоёрт хэлүүлсэн хэсгийг шүлэглэн өгүүлсэн мөр бадгуудыг хятадаар орчуулахдаа “我自己整军”(Би өөрөө цэрэг агтаа бэлтгэн засав”) гэснээр хязгаарлажээ.

МНТ-ны эхийг хятад хэлэнд товчлон орчуулсан байдлыг харуулах зарим жишээг энд дурдаж, сүүлийн үед хятад орчуулгыг монгол эхтэй харьцуулан судалсан өөрийн ажиглалтаас хуваалцахыг хүсэж байна. Үүнд:

Нэгдүгээрт, хятад хэлнээ орчуулсан энэхүү товч орчуулга нь МНТ шиг томоохон бүтээлийн тав, зургаан зуун жилийн өмнө хэрэгжүүлсэн анхны орчуулгын хувьд монгол, хятад хоёр хэлний аль алины орчуулгын түүхэнд тэмдэглэвэл зохих чухал үе шат болсон гэж үзэж байна.

Хоёрдугаарт, хятад орчуулга нь МНТ-ны агуулгыг бүрэн гаргасан, ялангуяа түүхэн баримт сэлт, он, сар, газар усны нэр, хүний нэрийг орхигдуулахгүйг хичээсэн байна.

Гуравдугаарт, тоочсон зүйлсийг хасаж, товчлон тайлбарлаж орчуулснаас гадна шүлэглэсэн, яруу найргийн хэсгүүдийг утгачлан орчуулсан байна. Үүнээс шалтгаалан МНТ-ны хятад орчуулгад уран сайхны тал нь хасагдаж түүхэн тал нь давамгайлжээ. Ийнхүү шүлэглэсэн утга уянгын чанартай хэсгүүдийг товчлон хассан боловч, монгол үндэстний ёс заншил, домог, адилтгал, зүйрлэл зэрэг хэл найруулгын онцлогийг хятад орчуулгад хангалттай сайн тусгажээ. Энэ бүхэн нь монголчуудын түүх, ёс заншилтай танилцах, судлах зорилгын үүднээс орчуулсантай холбоотой болов уу.

Дөрөвдүгээрт, энэхүү орчуулгын хэл нь XIII-XIV зууны үеийн хятад хэлэнд үүсэн буй болж байсан үзэгдлүүдийг тусгасан онцлогтой тул тэр үеийн хятад хэлний бусад дурсгалын зүйлстэй, тухайлбал Сун, Юаны үеийн жүжгийн зохиол хэл, монгол-хятад хөшөөний орчуулгын хэлтэй харьцуулан судалж болох чухал хэрэглэгдэхүүн юм.

Тавдугаарт, монгол хэл, түүх, уран зохиолын энэхүү гайхамшигт бүтээлийг гадаад хэлэнд орчуулсан хувилбаруудыг харьцуулан зэрэгцүүлж, нарийвчлан судлах нь нийт орчуулга зүй, олон орны орчуулгын уламжлалын судалгаанд хувь нэмэр оруулах бас нэг талбар гэж үзэж байна.

Ашигласан ном зохиол

1. 元朝秘史，四部叢刊三編史部，據民國二十五年四部叢刊三編影印元朝年
2. 元朝秘史，十五卷，連筠移業書，道光二十五年
3. 元秘史潤文，十五卷，清，王樹策，潤文，文海出版社
4. 大漠的世紀，學元時代的多元文化與藝術，National Palace Museum（台北）
5. Ligeti Lajos, A mongol titkos története, Budapest, 1964
6. Igor de Rachewiltz, Index to the Secret History of Mongols, 1972, Indiana University